



125

МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 363

Улаанбаатар хот

Г Тушаалд өөрчлөлт оруулах тухай Г

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2 дугаар заалт, Засгийн газрын 2011 оны “Дүрэм батлах тухай” 364 дүгээр тогтоол, “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5292:2011”, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний шинэчлэлийн стратегийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2013 оны 266 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээний үлгэрчилсэн загвар”-ын 4.1-д хууль тогтоомжид нийцүүлэн “Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй тохиролцон ажлын цагийг ээлжээр ажиллуулж, эх хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үйлчлэх хүрээний хүн амын хэрэгцээнд тулгуурлан иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хугацааг нэмэгдүүлэх арга хэмжээ авах” гэсэн заалт нэмсүгэй.

2. Үлгэрчилсэн загварын 5.1-ыг “Төсвийн санхүүжилтийг нэг иргэнд ногдох зардлаар тооцож улсын төсвөөс олгоно” гэснийг “Санхүүжилтийг хүн амын урд оны жилийн эцсийн статистик тоон мэдээлэлд үндэслэн нэг иргэнд ногдох зардлаар тооцож улсын төсвөөс олгоно” гэж өөрчилсүгэй.

3. Уг тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт”-ийн Тусламж, үйлчилгээний чанарын хэсэгт “Тусламж, үйлчилгээний хугацааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажилласан байдал болон нийт үйлчилсэн иргэдийн тоо” гэсэн заалтыг нэмсүгэй.

4. Эрүүл мэндийн сайдын “Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний багц батлах тухай” 2013 оны 248 дугаар тушаалын Оношлогоо шинжилгээний багцын жагсаалтад лабораторийн шинжилгээний төрлийг “шээсний ерөнхий шинжилгээ”, “цусны ерөнхий шинжилгээ”, “биохимийн шинжилгээ” байхаар нэмсүгэй.


5. Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн байгууллагуудын магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 2014 оны 7 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.2-т “Эрүүл мэндийн ажилтнууд орон тоогоор бүрэн ажилладаг байх” гэснийг Өрхийн эрүүл

032244

мэндийн төвийн үлгэрчилсэн дүрэм болон “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 5292:2011”– д заасны дагуу орон тоог бүрдүүлсэн байх гэж өөрчилсүгэй.

6. Энэ тушаалыг үндэслэн Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй өмнө байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

7. Тушаалын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я.Буянжаргал/-д даалгасугай.

САИД  Н.УДВАЛ